



ГАДААД ХЭРГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХЭРГИЙН ЯАМ, ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН ГАДААД ХЭРГИЙН ЯАМНЫ ХООРОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛД ГАРЫН ҮСЭГ ЗУРСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

2005 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар

Бангкок хот

Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Элбэгдорж Тайландын Вант Улсад ажлын айлчла хийх үеэр байгуулсан Монгол Улсын Гадаад хэргийн яам, Тайландын Вант Улсын Гадаад хэргийн яамны хооронд хамтран ажиллах тухай Протоколд монголын талаас Гадаад хэргийн дэд сайд А.Баттөр, тайландын талаас тайландын Гадаад хэргийн сайдын үүрэг гүйцэтгэгч Прича Лаохапонгчана нар Тайландын Засгийн газрын Thai Koo Fah ордоны Purple танхимд энэ өдөр гарын үсэг зурав.

Гарын үсэг зурах ёслолд монголын талаас Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Элбэгдорж, Монгол Улсаас Тайландын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Л.Даваагив, УИХ-ын гишүүн Г.Занданшатар, УИХ-ын гишүүн Д.Бат-Эрдэнэ, Сангийн дэд сайд Ч.Ганзориг, Ерөнхий сайдын гадаад бодлогын зөвлөх О.Энхбаяр, Мэдээлэл, харилцаа холбооны технологийн газрын дарга Ч.Сайханбилэг, Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх Г.Цогтсайхан, Засгийн газрын Хэвлэл, мэдээллийн албаны дарга Д.Болдхуяг, Төрийн ёслолын албаны дарга О.Нямдаваа, ГХЯ-ны Азийн газрын дэд захирал Ж.Сэрээжав, ГХЯ-ны Азийн газрын хоёрдугаар нарийн бичгийн дарга Х.Даваадорж, Монгол Улсаас Тайландын Вант Улсад суугаа ЭСЯ-ны I нарийн бичгийн дарга Мөнхөө, атташе Т.Төгсбилгүүн, тайландын талаас Боловсролын сайд Адисай Бодарамик, Гадаад хэргийн орлогч сайд Прича Лаохапонгчана, Ерөнхий сайдын Ерөнхий нарийн бичгийн дарга Проммин Лертсуридеж, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Пансак Виньяарат, ГХЯ-ны Байнгын нарийн бичгийн дарга Крит Гарнжана-Гунчорн, Үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжлийн газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ампон Киттиампон, Ерөнхий сайдын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Виразорн Кумпракоб, Тайландын Вант Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Жуллапонг Нонсричай, Засгийн газрын хэвлэлийн төлөөлөгч цагдаагийн генерал Чалёрмдеж Жомбунуд, Ерөнхий сайдын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Апинан Паванарит, ГХЯ-ны Зүүн Азийн газрын ерөнхий захирлын орлогч Чакарин Чаяапонг нарын албан ёсны төлөөлөгчид байлцав.

Энэхүү Протокол нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

ТЭМДЭГЛЭСЭН
АГ-ЫН II Н.Б.Д.

Х.ДАВААДОРЖ